



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 5/547

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Аймгийн хүндэт тэмдэг, үнэмлэх захиалан хийлгэх зардалд 2 430 000 төгрөгийн зарцуулсугай.
2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 2 430 000 төгрөг /Хоёр сая дөрвөн зуун гучин мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д, үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Б.ДҮГЭРЖАВ

D/Zax-A/547-Da

02 02735

Аймгийн Засаг даргын 2019-оны  
08 дугаар сарын 14-ний өдрийн  
А/547 дугаар захирамжийн хавсралт



“АЙМГИЙН ХҮНДЭТ ТЭМДЭГ” ЗАХИАЛАН ХИЙЛГЭХ ТӨСӨВ

Д.д	Зардлын төрөл зүйл	ХНэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/
1	Хүндэт тэмдэг /хайрцагтай/	Ш	200	10650	2 130.0
2	Үнэмлэхний хавтас-А5	ш	200	1500	300.0
	ДҮН				2 430.0